

## ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХОНГОР СУМЫН ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ ХӨТӨЛБӨР

### **Нэг.Хог хаягдлын өнөөгийн байдал:**

Хонгор сумын хэмжээнд хог хаягдал гаргагч эх үүсвэр цайны газар-5, төсөвт байгууллага-8, нам даралтын уурын зуух-3, тээврийн хэрэгсэл-493, хүн ам-6426, малчин өрх-581 тус тус байна.

Манай сумын хувьд хог хаягдлын төвлөрсөн 3 цэг ажиллаж 13 га талбайг хамаарч байна. Сумын хэмжээнд жилд дунджаар 2016 онд 787 тн, 2017 онд 768 тн хог хаягдал үүссэн байна. Мөн 2016 онд гэр хороолол-535 тн, орон сууцнаас-52 тн, Зам талбай-23 тн, Байгууллага, аж ахуйн нэгж-175 тн , 2017 онд гэр хороолол-578 тн, орон сууцнаас-50 тн, Зам талбай-18тн, Байгууллага, аж ахуйн нэгж-122 тн хог хаягдал тус тус гарч байна.

Мөн сар бүр айл өрх-1500, аптека,дэлгүүр-2000, аж ахуйн нэгж байгууллага-10000 төгрөгийн хог хаягдлын хураамж авч 2016 онд 1,444,800 төгрөг, 2017 онд 1,189,000 төгрөгний орлогыг орон нутгийн төсвийн орлого руу төвлөрүүлсэн.

Цаашид хүн амын тоо өсөхийн хэрээр төв суурин газруудын нягтрал ихсэж, төрөл бүрийн бүтээгдэхүүний хэрэглээ, сав баглаа боодол, үйлдвэржилт, барилгажилт өдөр ирэх тусам улам эрчимтэй явагдах хандлагатай байна. Хог хаягдлын хэмжээ нэмэгдэж байгаагийн гол шалтгаан нь бараа, бүтээгдэхүүний хэрэглээ огцом өсч байгаатай шууд холбоотой юм. Тухайлбал импортын бараа бүтээгдэхүүний өсөлт тэр дундаа химийн бодис, оффисын тоног төхөөрөмж, электрон бараа, аккумулятор, хуучин дугуй, авто тээврийн хэрэгслийн импорт өсөхийн зэрэгцээ уул уурхайн үйл ажиллагаанаас гарах хүнд металл, химийн хорт бодис агуулсан хаягдал, ашигласан тос масло, зай хураагуур, мөнгөн ус агуулсан хэмжлийн багаж хэрэгсэл, хаягдал бохир ус цэвэрлэх байгууламжийн лаг зэрэг үйлдвэрлэл, ахуйгаас гарах аюултай хог хаягдлын хэмжээ мөн адил ихэсч, хур хог хаягдлын хуримтлал бий болсоор байна.

Хог хаягдлын хэмжээ жилээс жилд өсч, хогийн төрөл, бүтцийн хувьд хортой аюултай болж байгаа өнөө үед хог хаягдлыг устгах үйл ажиллагаанд техник, технологийн шинэчлэл хийх, аюултай хог хаягдлыг олон улсад хүлээн

зөвшөөрөгдсөн аргаар устгах, барилгын болон хөдөө аж ахуйн төрөлжсөн төвлөрсөн хог хаягдлын цэгүүд байгуулах, хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулах, дахин ашиглах хэлбэрээр хэмжээг багасгах, устгах асуудлыг зохих шаардлагын түвшинд шийдвэрлэхэд санхүүгийн эх үүсвэр, хүн хүчний нөөц, дадлага туршлага, техник, тоног төхөөрөмж зэрэг дэд бүтцийн асуудал ихээхэн дутагдалтай байна. Мөн төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо сул, иргэдийн экологийн боловсрол мэдлэг дутмаг байна.

Иймд Сумын менежментийн хөтөлбөр, төлөвлөгөөг Ногоон хөгжлийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлснээр хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох хог хаягдлыг эргүүлэн ашиглах, дахин боловсруулах, байгальд булж устгах хаягдлын хэмжээг бууруулах, аюултай хаягдал хуримтлагдахаас сэргийлэх чадавхийг бүрдүүлэх, иргэд, оршин суугчдыг “ногоон” хэрэглээний соёлд сургах, амьдрах орчны эрүүл ахуйн зөв дадалд төлөвшүүлэх замаар ухамсар, мэдлэгийг дээшлүүлэх зэрэг үйл ажиллагааг төрийн байгууллагууд, орон нутаг, хувийн хэвшил, эрдэм шинжилгээ судалгаа, иргэний нийгмийн байгууллагуудын үүрэг оролцоотойгоор зохион байгуулсанаар хог хаягдлын зохистой менежментийн эхлэл тавигдах ба төв суурин газарт эрүүл ахуйн шаардлага хангасан төвлөрсөн хогийн цэгийн үйл ажиллагаа жигдэрч, нийт хог хаягдлын 20-оос доошгүй хувийг эргүүлэн ашиглах, хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах дадалд хэвших, аюултай хог хаягдал хуримтлагдахаас урьдчилан сэргийлэх чадавх бүрдсэн байна.

#### **Эрх зүйн үндэслэл шаардлага:**

Монгол Улсын Үндсэн хуульд Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй гэж заасан ба Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Ногоон хөгжлийн бодлого, шинэ бүтээн байгуулалт дунд хугацааны зорилтот хөтөлбөр зэрэг бодлогийн баримт бичгүүдэд хог хаягдлын менежментийг сайжруулж хог хаягдлыг бууруулах, хүн амын амьдрах тав тухтай эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх чиглэлээр зорилтуудыг тодорхойлсон байдаг. 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдөр Хог хаягдлын тухай хуулийг шинэчлэн баталсан бөгөөд уг хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2-т Хог хаягдлын менежментийг сайжруулах орон нутгийн хөтөлбөрийг баталж, биелэлтэд хяналт тавих гэж заасан. Мөн Засгийн газрын 2014 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн “Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр” батлах тухай 298 дугаар тогтоол, БОНХАЖСайдын 2015 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн “Хог хаягдлын

менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай А/435 дугаар тогтоолууд хөтөлбөрийг боловсруулах эрх зүйн үндэслэл болж байна.

### **Хоёр.Хөтөлбөрийн зорилго, зорилт**

**Зорилго:** Сумын хог хаягдлын менежментийг сайжруулах замаар хог хаягдлыг бууруулах, байгаль орчинд хал багатайгаар зайлуулах, эрүүл аюулгүй орчин нөхцлийг бүрдүүлэх, зөв дадлыг олгох замаар хог хаягдлын зохистой менежментийг төлөвшүүлж, цэвэр эрүүл орчинг бүрдүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

**Хөтөлбөрийн зорилгыг хангахын тулд дараах зорилтуудыг шийдвэрлэнэ:**

**Зорилт 1** Хог хаягдлын талаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, сумын хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох

**Зорилт 2** Хог хаягдлыг хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөгүйгээр ангилан ялгах, дахин боловсруулах дэвшилтэд техник технологийг нэвтрүүлэх замаар хог хаягдлыг багасгах, байгаль орчны бохирдлыг бууруулах

**Зорилт 3** Хог хаягдлыг бууруулах, ангилан ялгах, устгах орчны бохирдлыг багасгах талаар иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлэх

### **Гурав. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

**3.1. Хөтөлбөрийн нэгдүгээр зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:**

3.1.1 Монгол улсын Засгийн газрын 2015 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 288 дугаар тогтоол /Аргачлал батлах тухай/-ыг үндэслэн хог хаягдлын нормативыг тогтоож, холбогдох судалгааг хийнэ.

3.1.2 Тусгай хамгаалалттай газар нутаг, түүний орчны бүс дэх аялал жуулчлал эрхлэгчид хоорондоо нөхөрлөлийн холбоо үүсгэн, хог хаягдлын дундын сан байгуулж, хог хаягдлын менежментийн асуудлыг шийдвэрлэнэ.

3.1.3 Хөдөө орон нутгийн зам дагуу хог хаягдлыг хаяхыг хориглосон тэмдэгжүүлэлт, хог хаягдлын төвлөрсөн цэгийг тодорхой зайтайгаар байгуулна.

**3.2. Хөтөлбөрийн хоёрдугаар зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:**

3.2.1 Ахуйн хог хаягдлыг ангилан ялгах, зориулалтын уут сав хэрэглэх, хогийн цэгт хаях зэрэг дадал хэвшлийг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгаа явуулах, иргэдийн санал, санаачилгыг дэмжинэ.

3.2.2 Хот, суурин газарт эрүүл ахуйн шаардлага хангасан хогийн цэг байгуулах, өргөтгөсөн байна.

3.2.3 Төвлөрсөн хогийн цэг дээр ажиллах шаардлагатай машин механизм болон тусгай зориулалтын тээврийн хэрэгслээр хангана.

3.2.4 Нийтийг хамарсан баяр, ёслол, наадам болон бүх төрлийн үйл ажиллагааны үеэр хог хаягдал үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.

3.2.5 Бүх нийтийн цэвэрлэгээг улиралд нэгээс доошгүй удаа зохион байгуулна.

### **3.3 Хөтөлбөрийн дөрөвдүгээр зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:**

3.3.1 Хүүхэд залууст хог хаягдлын улмаас үүдэлтэй байгаль орчны доройтлын сөрөг үр дагаврын талаар сургалт, сурталчилгаа зохион байгуулна.

3.3.2 Хог хаягдлын менежментийг сайжруулах чиг үүрэг бүхий төрийн болон төрийн бус байгууллагуудын боловсон хүчнийг сургалтанд хамруулна.

3.3.3 Хог хаягдлыг бууруулах талаар иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад сургалт сурталчилгаа хийх зардлыг орон нутгаас санхүүжүүлнэ.

3.3.4 Аялал жуулчлалаар явж байгаа иргэдэд ил задгай хог хаягдал хаяхгүй байх талаар мэдээлэл сурталчилгаа тогтмол хийнэ.

3.3.5 Ахуйн хэрэглээнээс гарах хог хаягдлын ангилал, дахин боловсруулалт, химийн бодисын зөв зохистой хэрэглээ, хувь хүний нийгмийн хариуцлагын талаар олон нийтэд мэдлэг олгоно.

### **Дөрөв. Хог хаягдлын талаар иргэн аж ахуйн нэгж байгууллагын нийтлэг үүрэг**

#### **4.1 Сумын засаг даргын эрх, үүрэг :**

4.1.1 Хогны менежментийн ажлын хэсэг байгуулах

4.1.2 Аймгийн Засаг даргын баталсан нийтийн цэвэрлэгээний өдөр бүх нийтийг хамарсан цэвэрлэгээг тогтмол зохион байгуулж хэвшүүлэх

4.1.3 Хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хуваарийг батлах, хяналт тавих

4.1.4 Хог хаягдлын төвлөрсөн цэгийг тохижуулах шаардлагатай зардлыг орон нутгийн төсөвт суулгах

4.1.5 Хог хаягдалыг бууруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй техник хэрэгслүүдийг журмын дагуу ашиглах

4.1.6 Байгальд ээлтэй хаягдал бохирлыг бууруулахад хувь нэмрээ оруулж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжих, урамшуулах

4.1.7 Хог хаягдалын үйлчилгээний хураамжийг сар бүр төлөөгүй иргэн аж ахуйн нэгж байгууллага, худалдаа үйлчилгээний цэг салбаруудад хариуцлага тооцож ажиллах

#### **4.2 Багийн засаг даргын хүлээх үүрэг :**

4.2.1 Хог хаягдлын үйл ажиллагаанд хяналт тавих, иргэд, аж ахуйн нэгж байгууллагад хог хаягдлыг бууруулах ангилал , эргүүлэн ашиглах , дахин боловсруулах мэдээлэл сургалтыг тогтмол зохион байгуулах

4.2.2 Хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх аюултай хог хаягдал ил задгай хаясан шатаасан иргэн байгууллагыг тогтоон БОХУБайцаагчид мэдээллэх , хариуцлага хүлээлгэх , дахин ил задгай талбайд хог үүсгэхгүй байхад хяналт тавих

4.2.3 Хог хаягдалыг цуглуулах , тээвэрлэх эрх бүхий байгууллагын тээвэрлэлтийн график , хугацаа , давтамжинд хяналт тавьж , хамтран ажиллах

4.2.4 Нийтийг хамарсан цэвэрлэгээ зохион байгуулахад иргэдийг оролцуулах

4.2.5 Төв суурингаас алслагдсан хэсэг,бүлэг айл өрх,аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлыг зориулалтын цэгт хаяж байгаа эсэхэд тогтмол хяналт тавьж ажиллах

#### **4.3 Байгаль орчны хяналтын улсын байцаагч /БОХУБ/-ийн хүлээх эрх үүрэг :**

4.3.1 Хог хаягдлын тухай хууль тогтоомжоор тогтоосон захиргааны үүргийн биелэлтэнд хяналт тавих

4.3.2 Иргэд аж ахуйн нэгж байгууллага хог хаягдлаа зориулалтын цэгт хаяж байгаа эсэхэд хяналт тавьж,зөрчсөн этгээдээд арга хэмжээ авах,эрх бүхий албан тушаалтанд мэдээллэх

4.3.3 Нийтийг хамарсан цэвэрлэгээ зохион байгуулахад иргэдийг татан оролцуулахад багийн Засаг дарга нартай хамтран зохион байгуулах

4.3.4 Хог хаягдалын үйлчилгээний хураамжийг төсөвт төвлөрүүлэх ажлыг ТҮХэсэг , багийн Засаг дарга нартай хамтран зохион байгуулах

#### **4.4 Байгууллага,аж ахуйн нэгж,худалдаа үйлчилгээний цэгийн хүлээх үүрэг :**

4.4.1 Хог хаягдалыг эх үүсвэр дээр нь ангилж, цуглуулах,тээвэрлэх хог хаягдалын хэсэгт батлагдсан хуваарийн дагуу хүлээлгэн өгөх

4.4.2 Сар бүр хог хаягдалын үйлчилгээний хураамжийг төлж дэвтэр дээр сар бүр бичилт хийлгэх

4.4.3 Сар бүрийн 25 дотор хог хаягдалын үйлчилгээний хураамжийг банкна дахь 100190200947 тоот дансанд төлөх буюу эрх бүхий этгээдэд төлнө.

#### **4.5 Айл өрхийн хүлээх үүрэг :**

4.5.1 Хог хаягдлаа ангилан ялгаж зориулалтын саванд хадгалж батлагдсан хуваарийн дагуу хог хаягдал цуглуулах тээвэрлэх эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж ,байгууллагад хүлээлгэж өгөх

4.5.2 Зориулалтын цэгээс бусад цэгт хог хаяхгүй , хог шатаахгүй байх

4.5.3 Айл өрх бүр нийгмийн хариуцлагаа ухамсарлан сар бүр хог хаягдлын үйлчилгээний хураамжаа төлөх

4.5.4 Сар бүрийн 25 дотор хог хаягдлын үйлчилгээний хураамжийг банкна дахь 100190200947 тоот дансанд төлөх буюу эрх бүхий этгээдэд төлнө.

#### **Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилт:**

Хөтөлбөрийг 2018-2022 он хүртэл 2 үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

##### **5.1 Нэгдүгээр үе шат: 2018-2020 он**

Хог хаягдлыг бууруулах, зохион байгуулалтын орчныг боловсронгуй болгож, менежментийг сайжруулах, дэд бүтцийн болон санхүүгийн чадавхийг бэхжүүлэх, хог хаягдлыг бууруулах үйл ажиллагаанд иргэд, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, зөв дадал, хэвшлийг төлөвшүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

##### **5.2 Хоёрдугаар үе шат: 2020-2022 он**

Хог хаягдлаас үүдэлтэй орчны доройтлыг нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлж, ногоон хэрэглээний соёл, нийгмийн хариуцлагын ойлголтыг төлөвшүүлж, хог хаягдлын зохистой менежментийн тогтолцоо бий болж цэвэр эрүүл орчин бүрдэнэ.

##### **5.3 Хөтөлбөрийн санхүүжилт:**

5.3.1 Орон нутгийн төсөв

5.3.2 Хувийн хэвшлийн байгууллагаас гаргах хөрөнгө

5.3.4 Бусад эх үүсвэр

##### **5.4 Хог хаягдалыг цуглуулах,тээвэрлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх**

5.4.1 Хог хаягдлын орлого нь дараахь эх үүсвэрээс бүрдэнэ.

5.4.2 Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор батална.

5.4.3 Иргэн аж ахуйн нэгж төсөвт байгууллага худалдаа үйлчилгээний цэг салбар гадаад дотоодын амрагч жуулчдын хог хаягдалын үйлчилгээний хураамж.

5.4.4 Хог хаягдалын үйлчилгээний хураамжийг орон нутгийн төсөвт төвлөрүүлнэ.

### **5.5 Хог хаягдлын орлогыг зарцуулах**

5.5.1 Хог хаягдалын тухай хуулийн 20.3-д заасны дагуу төсвийн тухай хуулийн хүрээнд зохицуулалт хийж, сумын ИТХ-ын шийдвэрээр хог хаягдал тээвэрлэх, устгах тэдгээртэй холбоотой зардалд зарцуулна.

5.5.2 Хог хаягдлыг багасгахад чиглэгдсэн бусад арга хэмжээ

5.5.3 Хог хаягдлыг цуглуулах тээвэрлэх эрх бүхий иргэн аж ахуйн нэгж байгууллагад олгох үйл ажиллагааны зардлыг тухайн гэрээнд тодорхой тусгана.

5.5.4 Хог хаягдлын талаар сургалт сурталчилгаа хийх, гарын авлага тараах

### **Зургаа. Хүрэх үр дүн, тайлагнах хугацаа**

6.1 Хөтөлбөр хэрэгжсэнээр хог хаягдлын зохистой менежментийн эхлэл тавигдаж, хот суурин газарт эрүүл ахуйн шаардлага хангасан төвлөрсөн хогийн цэгийн үйл ажиллагаа жигдэрч ажиллана.

6.2 Хөтөлбөрийн хэрэгжилтийг жил бүрийн 12 дугаар сарын 25-ны дотор багтаан сумын ИТХуралд тайлагнаж, биелэлтийг сумын ИТХуралд дараа оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлж байх.

### **Долоо. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт:**

7.1 Хөтөлбөрийн хэрэгжилтээс гарах үр дүнгийн хяналт шинжилгээг тэргүүлэх зорилт тус бүрээр хийх бөгөөд гол үндсэн шалгуур нь:

7.1.1 Засгийн газраас батласан аргачлалын дагуу хог хаягдлын нормативыг тогтоож, холбогдох судалгааг хийн, уг аргачлалыг мөрдүүлнэ.

7.1.2 Энгийн хог хаяглыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах, журмыг батлуулж мөрдөх

7.1.3 Хог хаягдлын төвлөрсөн цэгийн талбайн хэмжээ бууралт, тохижилт аюултай болон эрүүл мэндийн хог хаягдал, барилгын хог хаягдлыг байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр хадгалах, устгах, цэвэрлэсэн хур хог хаягдлын талбай, хууль бусаар үүссэн хогийн цэгийн тооны бууралт /тн,жил/

7.1.4 Сумын хог хаягдлын үйлчилгээний төлбөр хураамжийг бүрэн төвлөрүүлж хууль тогтоомжийн дагуу зарцуулах/ төг /

7.1.5 Хог хаягдлын төвлөрсөн цэгийн хүчин чадал сайжирч, тусгай зориулалтын болон ахуйн хог тээврийн машины тооны өсөлт /га,тоо/

7.1.6 Хүний нөөцийн чадавхыг бэхжүүлсэн байдал, сургалтанд хамруулсан хүний тоо, зохион байгуулсан сургалтын тооны өсөлт /тоо/

7.1.7 Хог хаягдлын талаар иргэдээс ирэх гомдлын бууралт, /тоо/

## **Найм. Үнэлгээ хийх**

8.1 2018-2020 оны нэгдүгээр үе шатанд хэрэгжүүлэх арга хэмжээг бүрэн дуусгаж 2021 онд хөтөлбөрийн хэрэгжилтэд анхан шатны үнэлгээг хийнэ.

8.2 2021-2023 он хоёрдугаар үе шатанд хэрэгжүүлэх арга хэмжээг бүрэн дуусгаж 2024 онд хөтөлбөрийн хэрэгжилтэд төгсгөлийн үнэлгээ хийнэ.

## **Ес. Хог хаягдалтай холбогдолтой үйл ажиллагаанд хяналт тавих**

9.1 Хог хаягдалтай холбогдох журмын хэрэгжилтэнд ИТХ-ын дарга бүх шатны Засаг дарга ,ЗДТГ-ын дарга , Байгаль орчны Хяналтын Улсын байцаагч нар хяналт тавина.

9.2 Хог хаягдлын үйлчилгээний хураамжаас төсөвт төвлөрсөн орлого, зарцуулалтын байдалд Санхүүгийн албаны дарга, Татварын улсын байцаагч нар хяналт тавьж ажиллана.

9.3 Иргэд төрийн бус байгууллага хуулиар эрх хэмжээний хүрээнд энэхүү журмын биелэлтэнд хөндлөнгийн хяналт тавьж зөрчлийг арилгуулах талаар санал , хүсэлтээ холбогдох байгууллага , албан тушаалтанд тавьж болно.

## **Арав. Хариуцлага хүлээлгэх**

10.1 Хог хаягдалын тухай хуулийн 43-р зүйлийн дагуу хариуцлага хүлээлгэх Хог хаягдлын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Байгаль орчны хяналтын улсын байцаагч, цагдаа болон сум багийн Засаг дарга дараахь хариуцлага хүлээлгэнэ

Үүнд:

**43.1.3.**энэ хуулийн 10.2.4 /хог хаягдлаа зориулалтын хогийн сав болон цэгт хаях эсхүл хог хаягдал цуглуулж тээвэрлэх эрх бүхий байгууллагад шилжүүлэх/ ,10.2.7 /хог хаягдлын үйлчилгээний хураамжийг тогтоосон хугацаанд төлөх/-д заасныг зөрчсөн бол хүнийг гучин мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган төгрөгөөр торгох;

**43.1.4.**энэ хуулийн 10.3.1/ хог хаягдлыг дэд бүтцийн шугам хоолойд хаях /, 10.3.2/ нийтийн эдэлбэр газар, ногоон бүс, үерийн далан сувагт хог хаягдал хаях /- т заасныг зөрчсөн бол хүнийг тавин мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган төгрөгөөр торгох

**43.1.5.**энэ хуулийн 10.3.3/ хог хаягдлыг ил задгай шатаах/-т заасныг зөрчсөн хүнийг тавин мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг дөрвөн зуун мянган төгрөгөөр торгох

10.2 Хууль журмаар заасан албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан төрийн албан хаагчийг эсэргүүцсэн биед нь халдсан зэрэг зөрчил

гаргасан иргэн, аж ахуйн нэгж , байгууллагыг захиргааны хэргийн тухай хуулиар шийтгэл ноогдуулна.

ХЯНАСАН :

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ ДАРГА

/Б.ЛХАГВАСҮРЭН/

ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛСАН:

ХШҮ-ДАХ МЭРГЭЖИЛТЭН

/ Г.ОЮУНБОЛОР /

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны  
..... дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

**ХОНГОР СУМЫН ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ /2018-2023он/**

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжи х хугацаа	Хамтран ажиллах байгууллага	Хүрэх үр дүн	Хөрөнгийн Эх үүсвэр
<b>Зорилт 1. Хог хаягдлын талаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, сумын хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох</b>					
1.1	Засгийн газраас баталсан аргачлалын дагуу хог хаягдлын нормативыг тогтоож, холбогдох судалгааг хийн, уг аргачлалыг мөрдүүлнэ.	2018-2021	Сумын Засаг дарга	Хог хаягдлын норматив тогтоогдсон байна.	-
1.2	Сумын хог хаягдлын үйлчилгээний төлбөр хураамжийг бүрэн төвлөрүүлж хууль тогтоомжийн дагуу зарцуулах	2018-2021	Сумын ЗДТГ	Хог хаягдлын үйлчилгээний хураамж бүрдүүлэлт боловсронгуй болгоно.	-
1.3	Хог хаягдлын тооллого явуулж бүртгэлжүүлэн, мэдээллийн сан бүрдүүлж хог хаягдлын хэмжээ, урсгалыг байнгын хяналттай болгох;	2018-2021	Сумын ЗДТГ	Хог хаягдлын гаралт, тоо хэмжээг бүртгэлжүүлэх, мэдээллийн сантай болох.	орон нутгийн төсвөөс
1.4	Төвлөрсөн хогийн цэгийн үйл ажиллагааг гэрээгээр хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлэхийг дэмжинэ.	2018-2021	Сумын ЗДТГ	Үйлчилгээний чанар сайжирч, ажлын байр нэмэгдэнэ.	-
1.5	Амралт, аялал жуулчлалын газар нутаг, түүний орчны бүс дэх аялал жуулчлал эрхлэгчид хоорондоо нөхөрлөлийн холбоо үүсгэн хог хаягдлын дундын сан байгуулж, түүгээр хог хаягдлын асуудлаа шийдвэрлэдэг болгох	2018-2021	БОХУБ	Аялал жуулчлалын салбарын хог хаягдлын менежмент сайжирна.	
1.6	Сумын хог хаягдлын төвлөрсөн цэгээ тохижуулах, байнгын харуул хамгаалалт, хашаажуулах ажлыг зохион байгуулах	2018-2021	Сумын ЗДТГ	Төвлөрсөн хог хаягдлын цэгт ил задгай хог хаягдал хаях байдлыг бууруулах, ил задгай тарахаас урьдчилан	Орон нутгийн төсвөөс

				сэргийлсэн байна.	
1.7	Хог хаягдлыг бууруулах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, устгах үйл ажиллагаа эрхэлсэн болон хаягдалгүй технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, хувийн хэвшлийн үйл ажиллагааг дэмжих , урамшуулах	2018-2021	Сумын ЗДТГ	Урамшуулалын тогтолцоо бий болсон байх	Орон нутгийн төсвөөс
<b>Зорилт 2. Хог хаягдлыг хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөгүйгээр ангилан ялгах, дахин боловсруулах дэвшилтэд техник технологийг нэвтрүүлэх замаар хог хаягдлыг багасгах, байгаль орчны бохирдлыг бууруулах</b>					
2.1	Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгадаг тогтолцоог сумын төвд үе шаттай нэвтрүүлэх	2021-2023	Сумын ЗДТГ	Эх үүсвэр дээр нь ангилан ялгасан хог хаягдлын хэмжээ тн/жил	Орон нутгийн төсөв
2.2	Нийтийн эзэмшлийн гудамж талбай, болон аж ахуй нэгж байгууллагын орчинд хог хаягдлын сав, санамж самбар зэргийг хүрэлцэхүйц хэмжээгээр байрлуулах	2018-2020	ИТХ Сумын ЗДТГ	Хог хаягдлын савны тоо, санамж самбарын тоо нэмэгдсэн байх	Орон нутгийн төсөв
2.3	Сумын төвийн төвлөрсөн хогийн цэгт байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэж,стандартын дагуу хэрэгжүүлнэ.	2021-2023	Сумын ЗДТГ	Төвлөрсөн хогийн цэг Байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хийлгэж, менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангасан байх	Орон нутгийн төсөв
2.4	Орчны 50 метр газрын хог, цас, мөсийг хамгийн сайн цэвэрлэж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилна.	2018-2021	Сумын ЗДТГ	Орчны 50метр газрын хог хаягдал, цас мөсийг тогтмол цэвэрлэж хэвшүүлсэн байна.	-
2.5	Улсын болон орон нутгийн чанартай авто зам, замын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагаанд хяналт тавина	2018-2021	Сумын ЗДТГ	Улсын болон орон нутгийн чанартай авто зам, замын эзэнгүй хог хаягдлыг цэвэрлэж, дахин үүсэхээс сэргийлсэн байх.	Орон нутгийн төсөв
2.6	Сумын айл өрхүүд, аж ахуйн нэгж, байгууллагууд, үйлчилгээний газруудыг ангилан ялгах хогийн савтай болгоно.	2018-2020	ИТХ Сумын ЗДТГ	Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялга, зөв дадлыг хэвшүүлэх, эзэнгүй хог	Орон нутгийн төсөв

				хаягдал үүсэхээс урьдчилан сэргийлэх	
2.7	Хот, суурин газарт эрүүл ахуйн шаардлага хангасан хогийн цэг байгуулах, өргөтгөсөн байна.	2018-2023	Сумын ЗДТГ	Стандартын шаардлага хангасан ландфиллын аргаар хог хаягдлыг устгана.	Орон нутгийн төсөв
2.8	Төвлөрсөн хогийн цэг дээр ажиллах шаардлагатай машин механизм болон тусгай зориулалтын тээврийн хэрэгслээр хангана.	2021-2023	Сумын ЗДТГ	Төвлөрсөн хогийн цэгт хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах тээврийн хэрэгслээр бүрэн хангах	Орон нутгийн төсөв
2.9	Нийтийг хамарсан баяр, ёслол, наадам болон бүх төрлийн үйл ажиллагааны үеэр хог хаягдал үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.	2018-2023	ИТХ Сумын ЗДТГ	Иргэдийн тав тухай орчинд баяр ёслолоо тэмдэглэх, эрүү аюулгүй орчинд амьдрах орчин нөхцлийг бүрдүүлнэ.	Орон нутгийн төсөв
2.1 0	Бүх нийтийн цэвэрлэгээг улиралд нэгээс доошгүй удаа зохион байгуулна.	2018-2023	ИТХ Сумын ЗДТГ	Эзэнгүй хур хог хаягдлыг цэвэрлэх, дахин үүсэх байдлыг зогсоох	-
2.1 1	Сумын хэмжээнд хог хаягдлыг бууруулах, ангилан ялгах чиглэлээр болзолт уралдаан, аяныг тогтмол зохион байгуулна.	2021-2023	Сумын ЗДТГ	Байгаль орчныг хамгаалахад иргэдийн оролцоо нэмэгдэх, зөв дадал хэвшлийг бий болгох	-
<b>Зорилт 3. Хог хаягдлыг бууруулах, ангилан ялгах, орчны бохирдлыг багасгах талаар иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлэх</b>					
3.1	Хог хаягдлын талаар иргэдийн дунд зөв дадал зуршил, ухамсар сэтгэлгээг төлөвшүүлэх ажлыг тусгай хөтөлбөрийн дагуу олон нийтийн мэдээллийн хэрэгслээр системтэй зохион байгуулах;	2021-2023	Холбогдох байгууллага Сумын ЗДТГ	Иргэдийн хог хаягдлыг байгаль орчин үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах зөв дадлыг төлөвшүүлэх	-
3.2	Ахуйн хог хаягдлыг ангилан ялгах зориулалтын уут сав хэрэглэх, хогийн цэгт хаях зэрэг дадал хэвшлийг төлөвшүүлэхэд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулна.	2018-2020	Сумын ЗДТГ	Экологийн мэдлэг олгож, цэвэр эрүүл орчин бүрдүүлэхэд оролцоог	-

				хангана.	
3.3	Айл өрх, аж ахуйн нэгж, байгууллага бүр орчноо хог хаягдалгүй, цэвэр байлгахын төлөө хөдөлгөөн өрнүүлж түүнийг хэвшил болгон мөрдүүлэн “Цэвэр орчин” аяныг уламжлал болгон зохион явуулж байх /	2021-2023	Сумын ЗДТГ	Хог хаягдлын ил задгай хаях, шатаах байдлыг бууруулах, иргэдэд хог хаягдлыг эх үүсвэр нь ангилан ялгах, эзэнгүй хог хаягдал үүсэх байдлыг таслан зогсоох.	Орон нутгийн төсөв
3.4	Аялал жуулчлалаар явж байгаа иргэдэд ил задгай хог хаягдал хаяхгүй байх талаар мэдээлэл сурталчилгаа тогтмол хийж, хөдөө орон нутгийн зам дагуу хог хаяхыг хориглосон тэмдэгжүүлэлт санамж, самбар байрлуулах	2018-2021	Сумын ЗДТГ	Хяналтгүй хог хаягдлын тархалт буурна.	Орон нутгийн төсөв
3.5	Хог хаягдлыг бууруулахад орон нутгийн иргэд, байгаль хамгаалах чиг үүрэг бүхий иргэний нийгмийн байгууллага, төрийн бус байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх, олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах	2018-2021	БОХУБ Хувийн хэвшил	Олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх	Орон нутгийн төсөв
3.6	Хог хаягдлын менежмент хариуцсан нэгжүүдийн мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх, гадаадын болон дотоодын сургалтад хамруулж мэргэшүүлэх, туршлага судлуулах	2021-2023	Сумын ЗДТГ БОХУБ	Хүний нөөцийн чадавх бэхжүүлсэн байдал, түвшингээр	-

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:

Г.ОЮУНБОЛОР